

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 02 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2019 оны 02 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 02 дугаар сард дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:**



Тайлант хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 667 ширхгийг шинээр хэвлэн, 157 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 10 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 10 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 393 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 412 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын гурван иргэнд регистрийн дугаар олгосон. Үйлчилгээний танхимд 900 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд долоон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, долоон аж ахуйн нэгж, байгууллагын долоон гадаадын иргэний визийн зөвшөөрлийг шийдвэрлэлээ. Нийт 1794 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1518, биечлэн 276 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

2019 оны 02 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 7.7 хувиар, виз олголт 19.2 хувиар, хувийн урилга олголт 72.2 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 6.6 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 26.3 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 50.6 хувиар, түр ирэгчийн хасалт 9.8 хувиар, визийн сунгалт 42.6 хувиар тус тус буурсан, харин түр ирэгчийн бүртгэл 0.5 хувиар өссөн байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан ба хуульд заасан шалгуурыг хангаагүй нэг улсын гурван иргэн, харьяалалгүй нэг хүний хүсэлтийг буцаасан байна.


Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг улсын нэг иргэн, харьяалалгүй гурван хүний хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлээ.

Мөн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 29 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 35 иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 12 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 56 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан нэг улсын найман иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан ба иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй найман хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 12 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3041 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар дөрвөн төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцүүлэн хоёр байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунган, нэг байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн нэг байгууллагад зөвшөөрөл олгохоос татгалзсан байна. Түүнчлэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 12, шинээр үйл ажиллагаа зөвшөөрөл хүссэн нэг байгууллагын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 02 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллага байгаа бөгөөд үүнээс тайлант хугацаанд 63 байгууллагын 2018 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авсан байна.

Гадаад улсын гэр бүлд үрчлүүлсэн нэг хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн ба 2018 онд үрчлэлтийн дараа хяналт тавих тайлан ирүүлээгүй 36 хүүхдүүдийн судалгааг гаргаж Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлсэн.

## 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн найман улсын 13 иргэнийг байгууллагын даргын 12 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын даргын тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан нэг гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргасан тушаалыг хугацаанаас өмнө цуцалсан.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар хоёр улсын хоёр иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гурван удаагийн тушаалаар нэг улсын гурван иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 47 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 6 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 15 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн нэг захирамжаар гадаадын нэг иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр гурван улсын дөрвөн иргэнд гарах сануулга өгсөн байна.



Тайлангийн хугацаанд нэг удаагийн төлөвлөгөөт, есөн удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 84 аж ахуйн нэгж, байгууллага, 165 гадаадын иргэнийг хамруулсан ба 63 гадаадын иргэн, 57 аж ахуйн нэгж, байгууллага /92 гадаадын иргэн/, хоёр уригч иргэн /хоёр гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 62,920,000 /жаран хоёр сая есөн зуун хорин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

2019 оны 02 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 23.9 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн нэг дахин өссөн, харин зөрчил гаргасан гадаадын иргэн 18.2 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 60.0 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 53.6 хувиар тус тус буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний 2018 оны хэрэгжилтийг нэгтгэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргад, байгууллагын 2019 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд албан бичгээр тус тус хүргүүлэн ажиллалаа.

Мөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд тус байгууллагаас тусгах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгох болзол хангасан нэг, шинэчлэн тогтоох болзол хангасан гурван хаагчид байгууллагын даргын тушаалаар тус нэмэгдлийг олголоо.

Тус байгууллагаас “Бичиг баримтын нууцлал” сэдвээр сургалт зохион байгуулж өгөх тухай хүсэлтийг Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд гаргасны дагуу Хууль сахиулахын их сургууль дээр сургалт зохион байгуулагдлаа. Уг сургалтад төв болон Агаарын замын боомт хариуцсан газрын 15 албан хаагчийг хамрууллаа.

Байгууллагын мэдээллийн цагийн сургалтаар Дотоодын цэргийн 05 дугаар ангиас “Улсын онц чухал объект, түүний хамгаалалтын тухай ерөнхий ойлголт, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах хүчин зүйлс” сэдвээр, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтсээс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр, тус байгууллагын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсээс Авлигатай тэмцэх газраас хийгдсэн “Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний тайлан”, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсээс “Хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-ийн талаар танилцуулга, мэдээлэл хийсэн.

Тайлант хугацаанд байгууллагын мэдээллийн цагаар 4 удаагийн мэдээлэл, сургалт орж, давхардсан тоогоор 148 албан хаагч хамрагдсан байна.

Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч оролцож “НГ” /хөдөлмөр эрхлэх/ ангиллын визтэй холбоотой мэдээллээр тодруулга ярилцлага өглөө.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан гадаадын иргэдийн бүртгэлийн журамтай холбоотой

санамж мэдээллээр богино хэмжээний дүрс бичлэг, товч ярилцлага, зурагт хуудсыг англи, монгол хэлээр бэлтгэн олон нийтэд хүргэхэд бэлэн болсон.

Түүнчлэн Гадаадын хөрөнгө оруулагчдад тулгардаг хүндрэлийг багасгах, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжтэй холбоотой төрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудыг үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн “Invest in Mongolia center” нэг цэгийн үйлчилгээний төв нээгдсэнтэй холбогдуулан тус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Байгууллагын дарга сар шинийн баяраар олон хоног амрахтай холбогдуулан албаны үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах талаар албан хаагчдад холбогдох үүрэг чиглэл өгсөн. Тодруулбал байгууллагын төв байранд гадаадын иргэдэд зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлэх хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг батлан дотоод сүлжээгээр төв болон орон нутаг дахь газруудад хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын даргын 2018 оны А/107 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын газар, хэлтсээс архивт баримт хүлээн авах хуваарь”-ийн дагуу тайлант хугацаанд нийт 980 хадгаламжийн нэгжийг бүртгэлийн дагуу архивт хүлээн авч, сан хөмрөгийг нөхөн бүрдүүлсэн байна.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 38 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 29 өргөдөл шийдвэрлэгдэж, 9 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Тайлант хугацаанд байгууллагын Даргын дэргэдэх зөвлөл, Мэргэжлийн зөвлөл тус тус нэг удаа хуралдаж, тодорхой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллалаа.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

“Виз, зөвшөөрлийн бүртгэл хөтлөх журам”-ын төслийг боловсруулан байгууллагын даргын 2019 оны А/70 дугаар тушаалаар баталлаа.

Албан тушаалтнуудын 2018 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг /ХАСХОМ-1, ХАСХОМ-3/ албан бичгээр, /ХАСХОМ-2/ цахим хаягаар тус тус Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Шинээр томилогдохоор нэр дэвшсэн хоёр, шилжин томилогдохоор нэр дэвшсэн нэг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэв.

Засгийн газрын 2018 оны 306 дугаар тогтоолын дагуу Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем (APP)-ийг Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудалд нэвтрүүлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан “SITA” байгууллагын төлөөлөгчид Улаанбаатар хотноо 02 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэд байгууллагын дарга тэргүүтэй холбогдох ажлын хэсгийн гишүүдтэй хэлэлцээр хийх уулзалтын бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Байгууллагын дарга Японы Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Мияшита Хиромичи болон “Жайка” байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын төлөөлөгч Ёшино Сатоми нарыг хүлээн авч уулзлаа. Мөн Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Тайпэйн Худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын төлөөлөгч Хуан Куо Рун, дэд төлөөлөгч Жой Янь нартай хамтын ажиллагааны талаар уулзалт зохион байгуулав.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Бүгд Найрамдах Тажикстан улсын Душамбе хот дахь Хилийн менежментийн коллежийн олон улсын семинарт 02 дугаар сарын 03-аас 03 дугаар сарын 04-ний өдрүүдэд орон нутаг дахь газрын нэг хяналтын улсын байцаагчийг хамруулж байна.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд байгууллагын үйлчилгээний танхим дахь үйлчлүүлэгчийн дугаар дуудагч төхөөрөмж зөвхөн монгол хэлний сонголттой байсныг хөгжүүлэн англи, орос, хятад хэлний сонголтыг нэмсэн.

Албан хаагчдын сахилга хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулахтай холбогдуулан орон нутаг дахь газруудын ажлын цаг бүртгэлийн машины сүлжээний хаяглалыг төв сервертэй холбох ажлыг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр орон нутаг дахь газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг байгууллагын төвөөс хянах боломжтой боллоо.

### 2.4. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 01 дүгээр сарын мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын албанд, статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөн Даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн албан бичгээр, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний 2018 оны төлөвлөгөөний биелэлт болон 2019 онд хяналт-шинжилгээний чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталгаажуулан албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээ.

“IRIM” хараат бус судалгааны хүрээлэнгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу 81 төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаст хийсэн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал 2018: Мониторингийн тайлан”-тай танилцан, тус тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Байгууллагын даргын 2019 оны 02 дугаар удирдамжийн дагуу байгууллагын эмчийн буюу эрүүл мэндийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт бус шалгалтыг холбогдох баримт бичигтэй танилцаж судлах хэлбэрээр явуулж байна. Мөн байгууллагын 220 албан хаагчийн боловсрол, мэдлэг, мэргэшил, туршлагыг нотлох баримтад тулгуурлан байгууллагын даргын 2018 оны А/441 дүгээр тушаалд заасан албан тушаал, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлага, шалгуурыг хангаж буй эсэхэд дотоод хяналт шалгалтыг хийж байна.

2019 оны нэгдүгээр улиралд хилийн боомтод ажиллах хуваарийн баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын хилээр 126 орны 46417 гадаадын иргэн хил нэвтэрснээс түүвэрчилж 476 гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавихад Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй иргэний гарах-орох визгүй, бүртгэлийн журам зөрчсөн иргэнийг бүртгэл хасалтгүй, торгуулийн арга хэмжээ аваагүй зэрэг зөрчил илэрснийг Хил хамгаалах байгууллагын холбогдох анги, салбарт хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

## 2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 02 дугаар сард 952.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 599.4 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 02 дугаар сарын байдлаар 443,7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 118.8 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 13,7 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Албан хаагчдын нормын хувцас, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 322 сая төгрөгийн өртөг бүхий тендер шалгаруулалтыг цахимаар зарлалаа.

2019 онд хийх бүтээн байгуулалтын хүрээнд байгууллагын хурлын танхимыг өргөтгөх засварын ажлыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

## 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын даргын 2019 оны 09/03 дугаар удирдамжийн дагуу Захиргаа удирдлагын газрын дарга, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн нар Ховд аймаг дахь Баруун бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Агаарын замын боомт хариуцсан газар “Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар” сэдэвт сургалт зохион байгуулж тус газрын 24 албан хаагч, Дорноговь аймаг дахь газар Гэр бүл хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төвтэй хамтран “Байгууллага хамт олны харилцаа ба хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 11 албан хаагч, Зүүн бүс дэх газар хилийн боомт, орон нутаг дахь хяналтын улсын байцаагч нарын сургалтыг зохион байгуулж тус газрын 11 албан хаагч хамрагдсан байна.

Мөн Зүүн бүс дэх газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан хөтөлбөрийн дагуу хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээнд оролцож тус байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй чиг үүрэг, иргэд үйлчлүүлэгчдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР